



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар A/288

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт, 35.13 дахь хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалт, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй барилгын ажил гүйцэтгэж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, дүгнэлт гарган цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2.Хяналт, шалгалтын дүн болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан холбогдох шийдвэрийн төслийн хамт 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Ж.Сандагсүрэн)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110201244

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
03 дугаар сарын 17-ны өдрийн  
А/288 дугаар захирамжийн  
хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч: Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч
- Гишүүд:
- Нийслэлийн Засаг даргын захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан Ахлах зөвлөх;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газрын дарга;
  - Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга;
  - Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга;
  - Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дэд дарга
  - “Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын дарга;
  - “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр);
  - “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр).
- Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга